



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

XXXVII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XXXVII дугаар хурал 2020 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт Төрийн ордон дахь "Их Эзэн Чингис хаан" танхимд 93.7 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдвар /Ковид19/-ын нөхцөл байдлын мэдээлэл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын танилцуулга;

*Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,*

2. Улсын онцгой комиссын дэргэдэх "Эрдэмтдийн зөвлөл"-ийн зөвлөмжийн талаарх мэдээлэл;

АШУУИС-ийн захирал, доктор, профессор Л.Хүрэлбаатар,

3. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилэн шилжүүлэх болон зарим засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай;

*Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
бригадын генерал Г.Ариунбуян,*

4. Хилийн боомтуудын талаар авах зарим арга хэмжээний тухай;

*Уул, уурхай хүнд үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Ёндон,*

*Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн,
бригадын генерал Ж.Бямбасүрэн,*

5. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян нарт:

1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэл, Архангай, Сэлэнгэ аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх, бусад аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

Хоёр. Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Ёндон,

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Гаалийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,

Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн,

Дорнод аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт.

2.1. Монгол, Оросын хилийн Эрэнцав төмөр замын боомтыг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүрийн 2 болон 4 дэх долоо хоногт

халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулан, эвхөн газрын тосны бүтээгдэхүүний импорт, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт хийх зорилгоор ажиллуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх;

2.2. Хилийн Эрээнцав боомтыг нээн ажиллуулахтай холбогдуулан ХХЕГ, ЦЕГ, МХЕГ-аас 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг 1 сарын хугацаатай томилж ажиллуулах,

Гурав. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Болор-Эрдэнэ,


Улсын онцгой комиссын гишүүд,

Аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

3.1. Иргэд олноор үйлчлүүлдэг, худалдаа, үйлчилгээний газар, аж ахуйн нэгжүүдийн угтах, нэвтрэх хэсэг, нийтийн тээврийн хэрэгсэл зэрэг газруудад тухайн цэг, байршлыг илэрхийлсэн тэмдэглэгээг (QR код) байршуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих;

3.2. Цэг, байршлыг илэрхийлсэн тэмдэглэгээг www.119.mn веб сайтад нэгдсэн байдлаар үүсгэж түгээх;

3.3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед олон нийтийн газар, хүн олноор цугларах тухайн цэгт нэвтэрсэн иргэн цахим хэлбэрээр бүртгүүлэх шийдлийг Сангийн яамны "e-barimt" аппликейшн дээр хөгжүүлж байгаа бүртгэл хяналтын аппликейшнийг ашиглан тухайн цэгээр үйлчлүүлсэн, нэвтэрсэн иргэд бүртгэл хийлгэх, коронавируст халдвар /Ковид-19/-ын талаарх мэдээлэл, ойр болон дам хавиталтай холбоотой сэрэмжлүүлэг мэдээг хүлээн авах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд сурталчилж ажиллах;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА  Б. БОЛОР-ЭРДЭНЭ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА  Т. МӨНХДОРЖ